



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/22

Улаанбаатар хот

Агаарын чанарыг автоматаар хянах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2 дахь заалт, Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2016 оны А/02, 2019 оны А/360 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Агаарын чанарыг автоматаар хянах багаж, тоног төхөөрөмжийг 21 аймгийн төвд суурилуулсантай холбоотойгоор агаарын чанарыг автоматаар хянах шинжилгээний ажлыг 2026 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлүүлсүгэй.

2. Агаарын чанарын дүн мэдээг MAMIS программаар боловсруулах, дүн шинжилгээ хийх, баталгаажуулах, багаж, тоног төхөөрөмжийн тохируулга үйлчилгээ, мэдээ, мэдээллийн тасралтгүй ажиллагаа, мэдээний чанарт хяналт тавьж, мэдээллээр үйлчилж ажиллахыг аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга нар, Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн захирал (Б.Цацрал), Уур амьсгалын өөрчлөлт, орчны шинжилгээний хэлтсийн дарга (Н.Галцог) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Баянхонгор аймгийн агаарын чанарын станцыг "Баянхонгор-02" гэж нэрлэж, "10602" дугаарын индекс, Орхон аймгийн агаарын чанарын станцыг "Эрдэнэт-03" гэж нэрлэж, "11403" дугаарын индекс олгосугай.

4. Агаарын чанарын станц дахь багаж, тоног төхөөрөмжид үзлэг үйлчилгээ, шалгалт тохируулга хийх давтамжийн хуваарийг хавсралтаар баталсугай.

5. Агаарын чанарыг автомат багажаар хянах болсонтой холбоотойгоор мөнгөн уст бодисын хэрэглээг зогсоосугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын сүлжээний газар (Д.Уламбаяр)-т даалгасугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

**АГААРЫН ЧАНАРЫН СТАНЦ ДАХЬ
БАГАЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИД ҮЗЛЭГ
ҮЙЛЧИЛГЭЭ, ШАЛГАЛТ ТОХИРУУЛГА
ХИЙХ ДАВТАМЖ, ХУВААРЬ**

Агаарын чанарын станц дахь багаж, тоног төхөөрөмжид үзлэг үйлчилгээ, засвар, шалгалт тохируулга хийх, техникийн ашиглалтын тэмдэглэл, мэдээллийг гарын үсэг зурж баталгаажуулан хадгална.

1. ӨДӨР ТУТАМ ШАЛГАХ

(SO2, O3, NOx, CO автомат анализатор, цаг уурын хэмжих хэрэгсэл)

д/д	Тогтмол шалгах үзүүлэлтүүд
1	Агаарын чанарын станц дахь UPS-ийн гаралтын хүчдэл болон батарейн цэнэгийн төлөвийг шалгах
2	Агаарын чанарын станц дахь AVR-ийн гаралтын хүчдэлийг шалгах
3	Агаарын чанарын станц дахь өрөөний температурыг шалгах (21–25 хэм байх)
4	Сорьцын хоолойн чийгшлийг шалгах
5	Автомат багаж, тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтэд тулгуурлан анализаторуудын агаар соруулах хурдыг шалгах
6	Тохируулгын стандарт хийн даралтыг шалгах
7	Мэдээ дамжуулах төхөөрөмж (Data Logger)-ийн дэлгэц болон гаралтын бичлэгийг шалгах
8	Модемын холболтын /харилцаа холбооны төлөвийг шалгах
9	Мэдээ дамжуулах төхөөрөмж (Data Logger)-ийн одоогийн цаг зөв эсэхийг шалгах
10	Цаг уурын хэмжих хэрэгслийн мэдрэгчийн цэвэр байдал болон ажиллагааны төлөвийг шалгах

2. ДОЛОО ХОНОГ ТУТАМ ШАЛГАХ

2.1. PM2.5 болон PM10 анализатор

д/д	Тогтмол шалгах үзүүлэлтүүд
1	Насос
2	Фильтерийн цаас, насос болон фильтерийн шилжилтийг шалгах
3	Бетта тоололтын хэмжилтийн техникийн үзүүлэлтийг шалгах
4	Сорьцын температур ба даралтыг шалгах

2.2. Нүүрстөрөгчийн дутуу ислийн анализатор

д/д	Тогтмол шалгах үзүүлэлтүүд
1	Фильтер
2	Багажийн агаарын оролтын тоосноос хамгаалах фильтерийг шалгах, бохирдсон бол солих
3	Оптик камерын температур болон нил улаан гэрэл (IR) -ийн мэдрэмжийг шалгах
4	Сорьцын температур ба даралтыг шалгах
5	Тэг тохируулга хийх

2.3. Озоны анализатор

д/д	Тогтмол шалгах үзүүлэлтүүд
1	Багажийн агаарын оролтын тоосноос хамгаалах фильтерийг шалгах, бохирдсон бол солих

2	UV ламп шалгах
3	UV лампыг эрчмийг шалгах
4	Сорьцын температур ба даралтыг шалгах
5	Тэг тохируулга хийх

2.4. Азотын ислийн анализатор

д/д	Тогтмол шалгах үзүүлэлтүүд
1	Багажийн агаарын оролтын тоосноос хамгаалах фильтерийг шалгах, бохирдсон бол солих
2	Урвалын камер, фотон үржүүлэгч хоолой, молибден хувиргуурын температурыг шалгах
3	Сорьцын температур ба даралтыг шалгах
4	Тэг тохируулга хийх

2.5. Хүхэрлэг хийн анализатор

д/д	Тогтмол шалгах үзүүлэлтүүд
1	Багажийн агаарын оролтын тоосноос хамгаалах фильтерийг шалгах, бохирдсон бол солих
2	Хэмжлийн камер болон сорьцын температурыг шалгах
3	Хэт ягаан гэрлийн ламп (UV lamp)-ны эрчим, фотон үржүүлэгч хоолой (PMT) -н гаралтын сигналыг шалгах
4	Тэг тохируулга хийх

3. 14 ХОНОГ ТУТАМ ШАЛГАХ

3.1. PM2.5 болон PM10 анализатор

д/д	Тогтмол шалгах үзүүлэлтүүд
1	Багажийн агаар соруулах хурдыг шалгах

3.2. Нүүрстөрөгчийн дутуу ислийн анализатор

д/д	Тогтмол шалгах үзүүлэлтүүд
1	Багажийн агаарын оролтын тоосноос хамгаалах фильтер солих

3.3. Озоны анализатор

д/д	Тогтмол шалгах үзүүлэлтүүд
1	Багажийн агаарын оролтын тоосноос хамгаалах фильтер солих

3.4. Азотын ислийн анализатор

д/д	Тогтмол шалгах үзүүлэлтүүд
1	Багажийн агаарын оролтын тоосноос хамгаалах фильтер солих

3.5. Хүхэрлэг хийн анализатор

д/д	Тогтмол шалгах үзүүлэлтүүд
1	Багажийн агаарын оролтын тоосноос хамгаалах фильтер солих

4. САР БҮР ШАЛГАЖ ТОХИРУУЛГА ХИЙХ

4.1. PM2.5 болон PM10 анализатор

д/д	Тогтмол шалгах үзүүлэлтүүд
1	Туузан фильтерийн зарцуулалт, явцыг шалгах, шаардлагатай бол солих
2	Сорьцын температур ба даралтыг шалгаж тохируулга хийх
3	Бетта тоололтыг шалгаж тохируулах
4	Ажиллагааны алдааг шалгаж, илэрсэн алдааг засах
5	Урсгалын хурдыг шалгаж тохируулга хийх
6	Толгойн хэсэг болон циклоныг цэвэрлэх

4.2. Нүүрстөрөгчийн дутуу ислийн анализатор

д/д	Тогтмол шалгах үзүүлэлтүүд
1	IR эх үүсвэрийн эрчмийг шалгаж тохируулах
2	Хийн хосолмол шүүлтүүрийн эргэлтийг шалгаж тохируулах
3	Сорьцын температур ба даралтыг шалгаж тохируулах
4	Тэг тохируулга хийх
5	Span тохируулга хийх

4.3. Озоны анализатор

д/д	Тогтмол шалгах үзүүлэлтүүд
1	UV лампын эрчмийг шалгаж тохируулах
2	Сорьцын температур ба даралтыг шалгаж тохируулах
3	Тэг тохируулга хийх
4	Span тохируулга хийх

4.4. Азотын ислийн анализатор

д/д	Тогтмол шалгах үзүүлэлтүүд
1	Урвалын камер, фотон үржүүлэгч хоолой, молибден хувиргуурын температурыг шалгах
2	Молибден хувиргуурын үр ашгийг шалгаж, шаардлагатай бол солих
3	Озоны генераторыг шалгах, шаардлагатай бол солих
3	Сорьцын температур ба даралтыг шалгах
4	Тэг тохируулга хийх
5	Span тохируулга хийх

4.5. Хүхэрлэг хийн анализатор

д/д	Тогтмол шалгах үзүүлэлтүүд
1	UV лампын эрчмийг шалгаж тохируулга хийх
2	Харанхуй гүйдлийг (dark current) шалгаж тохируулах
3	Сорьцын температур ба даралтыг шалгаж тохируулах
4	Тэг тохируулга хийх
5	Span тохируулга хийх

5. ЖИЛ БҮР ШАЛГАХ /СОЛИХ/**5.1. PM2.5 болон PM10 анализатор**

д/д	Тогтмол шалгах үзүүлэлтүүд
1	Сорьц дамжуулах хоолойг цэвэрлэх
2	Шаардлагатай сэлбэг хэрэгслийг солих /даралт мэдрэгч гэх мэт/
3	Агаар соруулах насос солих /шаардлагатай тохиолдолд/
4	Сорьцын сорьц дамжуулах хоолойг цэвэрлэх, солих

5.2. Нүүрстөрөгчийн дутуу ислийн анализатор

д/д	Тогтмол шалгах үзүүлэлтүүд
1	Сорьц дамжуулах хоолойг цэвэрлэх
2	Сэлбэг хэрэгслийг шалгах, /солих /лампын гэх мэт/
3	Агаар соруулах насос солих /шаардлагатай тохиолдолд/
4	Сорьц дамжуулах хоолойг цэвэрлэх, /солих/

5.3. Озоны анализатор

д/д	Тогтмол шалгах үзүүлэлтүүд
1	Тэг скруббэрийг шалгах, /солих/
2	Абсорбцийн хоолойг цэвэрлэх, /солих/
3	Сэлбэг хэрэгслийг шалгах, /солих /лампын гэх мэт/
4	Агаар соруулах насос солих /шаардлагатай тохиолдолд/

5	Сорьц дамжуулах хоолойг цэвэрлэх, /солих/
---	---

5.4. Азотын ислийн анализатор

д/д	Тогтмол шалгах үзүүлэлтүүд
1	Нүүрсэн /Charcoal/ шүүлтүүрийг шалгах /солих/
2	Сорьцын хоолойг цэвэрлэх
3	Сэлбэг хэрэгслийг шалгах, солих /ламп гэх мэт/
3	Агаар соруулах насос солих /шаардлагатай тохиолдолд/
4	Сорьц дамжуулах хоолойг цэвэрлэх /солих/

5.5. Хүхэрлэг хийн анализатор

д/д	Тогтмол шалгах үзүүлэлтүүд
1	Сорьцын хоолойг цэвэрлэх
2	Скрубберийг шалгах /солих/
3	Сэлбэг хэрэгслийг шалгах, солих /ламп гэх мэт/
4	Агаар соруулах насос солих /шаардлагатай тохиолдолд/
5	Сорьц дамжуулах хоолойг цэвэрлэх /солих/

Жич: Өдөр тутам, 7 хоног, 14 хоног, сар тутам шалгах үед тохиргоо алдагдсан байвал шалгалт тохируулгыг хийж, эвдэрсэн тохиолдолд солино.

**ҮЗЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ, ШАЛГАЛТ ТОХИРУУЛГА ХИЙСЭН
АЛБАН ХААГЧ:**

АЛБАН ТУШААЛ

НЭР

ГАРЫН ҮСЭГ

.....

.....

.....

..... он сар өдөр